



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Аудитын код: БНА-2021/15/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням: Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ 7
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.БУЯНТОГТОХ ТАНАА

2021. 02 25 № 2/99

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ 7

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага нь Сумын Засаг дарга, аймгийн Боловсрол, соёл урлагийн газартай гурвалсан гэрээ байгуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

• 005070090

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,817,821.01	135,159,778.32
33	АВЛАГА	00.00	11,116,412.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	890,465.00
335	Бусад авлага	00.00	10,225,947.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	10,225,947.00
35	БАРАА МАТЕРИАЛ	78,817,821.01	124,043,366.32
351	Түүхий эд материал	12,204,900.00	10,687,200.00
35110	Тусгай зориулалттай материал	12,204,900.00	10,687,200.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	25,000,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	173,700.00
354	Хангамжийн материал	66,612,921.01	88,182,466.32
35410	Бичиг хэргийн материал	976,240.00	1,744,570.00
35420	Аж ахуйн материал	48,806,081.01	69,857,496.32
35440	Түлш, шатах тослох материал	190,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	11,913,000.00	11,913,000.00
35460	Хүнсний материал	1,405,200.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	3,322,400.00	4,667,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,286,986,156.21	1,298,141,803.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,286,986,156.21	1,298,141,803.12
392	Биет хөрөнгө	1,269,490,156.21	1,280,645,803.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,253,683,054.47	1,183,417,394.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-111,946,806.69	-55,991,623.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	131,662,381.07	171,440,633.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,610,928.02	-120,805,776.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,334,215.11	117,704,215.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,676,510.72	-68,042,660.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,735,903.98	38,735,903.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,460,790.20	-7,977,220.32
39217	Ном	17,769,637.21	22,164,937.21
393	Биет бус хөрөнгө	17,496,000.00	17,496,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,496,000.00	17,496,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,365,803,977.22	1,433,301,581.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	794,422.41	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	794,422.41	00.00
413	Өглөг	794,422.41	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	655,947.41	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	138,475.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,365,009,554.81	1,433,301,581.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,365,009,554.81	1,433,301,581.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	319,214,873.32	319,214,873.32
51101	Өмч: - төрийн	319,214,873.32	319,214,873.32
512	Хуримтлагдсан үр дүн	110,483,070.77	213,250,097.40
51210	Өмнөх үеийн үр дүн	110,483,070.77	144,958,070.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	68,292,026.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	935,311,610.72	900,836,610.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,365,803,977.22	1,433,301,581.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	935,504,255.98	1,082,557,421.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,209,828.00	32,469,903.61
120	Нийтлэг татварын бус орлого	12,209,828.00	32,469,903.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,209,828.00	32,469,903.61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,800.00	2,140,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,170,028.00	30,329,803.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	923,294,427.98	1,050,087,518.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	814,376,694.98	911,478,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	48,333,294.98	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	766,043,400.00	911,478,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	44,748,018.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	44,748,018.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,861,500.00	93,861,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,861,500.00	93,861,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,056,233.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,056,233.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	852,401,917.46	1,014,265,394.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	852,401,917.46	1,014,265,394.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	817,686,024.46	899,838,726.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	521,312,930.56	593,267,660.10
210101	Үндсэн цалин	521,312,930.56	412,049,984.10
210102	Нэмэгдэл	00.00	135,270,581.00
210104	Урамшуулал	00.00	45,947,095.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,504,591.72	78,447,098.49
210201	Тэтгэврийн даатгал	64,504,591.72	58,235,728.43
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,694,882.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	5,814,273.25
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,422,180.61
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	9,280,034.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,540,762.00	90,659,067.00
210301	Гэрэл, цахилгаан	3,685,102.00	2,901,257.00
210302	Түлш, халаалт	92,453,660.00	86,657,810.00
210303	Цэвэр, бохир ус	1,402,000.00	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,768,310.00	26,306,931.30
210401	Бичиг хэрэг	4,746,340.00	3,216,270.00
210402	Тээвэр, шатахуун	4,832,970.00	5,072,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,533,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	3,411,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	655,000.00
210408	Бараа материал акталсны зардал	10,189,000.00	12,418,936.30
2105	Нормативт зардал	51,868,480.00	33,721,050.00
210502	Хоол, хүнс	44,985,080.00	31,284,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,883,400.00	2,436,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,779,300.00	4,069,700.00
210604	Урсгал засвар	4,779,300.00	4,069,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,905,500.00	1,094,000.00
210702	Дотоод албан томилолт	4,905,500.00	1,094,000.00

**Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	625,500.00	3,265,315.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,500.00	2,815,315.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,380,650.18	69,007,905.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	380,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	587,000.00	120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,413,650.18	68,887,905.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,715,893.00	114,426,668.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,825,229.00	60,921,718.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,568,529.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	713,520.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,913,700.00	14,580,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	19,739,748.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	25,008,270.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,343,000.00	879,280.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,621.00	342,433.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,621.00	342,433.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,877,043.00	53,162,517.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,877,043.00	53,162,517.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	83,102,338.52	68,292,026.63
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,915,762.16	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,915,762.16	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,915,762.16	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	72,186,576.36	68,292,026.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	875,000,933.00	1,052,227,618.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,800.00	2,140,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,800.00	2,140,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,800.00	2,140,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,800.00	2,140,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	874,961,133.00	1,050,087,518.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	766,043,400.00	911,478,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	766,043,400.00	911,478,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	44,748,018.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	44,748,018.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,861,500.00	93,861,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,861,500.00	93,861,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,056,233.00	00.00

**Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,056,233.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	875,000,933.00	999,090,718.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,000,933.00	999,090,718.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	840,061,463.00	884,259,250.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,489,834.00	593,085,905.00
210101	Үндсэн цалин	402,191,040.00	411,868,229.00
210102	Нэмэгдэл	67,590,907.00	135,270,581.00
210104	Урамшуулал	49,707,887.00	45,947,095.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,822,180.00	80,451,213.00
210201	Тэтгэврийн даатгал	49,474,380.00	57,735,196.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,526,600.00	7,290,817.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,834,100.00	3,925,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	701,500.00	1,110,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,285,600.00	10,388,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,347,879.00	90,519,067.00
210301	Гэрэл, цахилгаан	3,492,219.00	2,951,257.00
210302	Түлш, халаалт	92,453,660.00	86,467,810.00
210303	Цэвэр, бохир ус	1,402,000.00	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,166,000.00	17,853,730.00
210401	Бичиг хэрэг	3,889,500.00	1,369,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,675,000.00	5,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,703,000.00
210404	Ном, хэвлэл	3,108,600.00	3,607,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	575,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,312,900.00	5,499,530.00
2105	Нормативт зардал	48,151,500.00	45,652,065.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	691,000.00	2,004,500.00
210502	Хоол, хүнс	45,908,400.00	31,143,865.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,552,100.00	12,503,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,750,000.00	35,969,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	3,400,000.00
210602	Тавилга	13,500,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,750,000.00	00.00
210604	Урсгал засвар	36,500,000.00	32,569,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,025,500.00	1,094,000.00
210702	Дотоод албан томилолт	2,025,500.00	1,094,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,178,500.00	1,806,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	778,500.00	1,356,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,130,070.00	17,826,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,168,000.00	14,650,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,962,070.00	3,176,870.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,939,470.00	114,831,468.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,048,806.00	61,326,518.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,014,206.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,691,600.00	14,865,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	44,748,018.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,343,000.00	1,712,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,621.00	342,433.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,621.00	342,433.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,877,043.00	53,162,517.00

**Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,877,043.00	53,162,517.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	53,136,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	53,136,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	53,136,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	53,136,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	53,136,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-53,136,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	935,311,610.72	110,483,070.77	1,365,009,554.81
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	935,311,610.72	110,483,070.77	1,365,009,554.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	34,475,000.00	34,475,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,214,873.32	935,311,610.72	144,958,070.77	1,399,484,554.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-34,475,000.00	00.00	-34,475,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	68,292,026.63	68,292,026.63
D09	20120оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	213,250,097.40	1,433,301,581.44


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,005,339,500.00	951,843,550.00	-53,495,950.00	94.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,005,339,500.00	951,843,550.00	-53,495,950.00	94.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	982,378,700.00	935,265,050.00	-47,113,650.00	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	601,471,900.00	593,085,905.00	-8,385,995.00	98.6
210101	Үндсэн цалин	407,167,400.00	411,868,229.00	4,700,829.00	101.2
210102	Нэмэгдэл	135,499,200.00	135,270,581.00	-228,619.00	99.8
210104	Урамшуулал	58,805,300.00	45,947,095.00	-12,858,205.00	78.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,313,800.00	80,451,213.00	-6,862,587.00	92.1
210201	Тэтгэврийн даатгал	62,094,900.00	57,735,196.00	-4,359,704.00	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,304,700.00	7,290,817.00	986,117.00	115.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,043,700.00	3,925,700.00	-1,118,000.00	77.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,261,000.00	1,110,800.00	-150,200.00	88.1
210205	Эрүүл мэндийн даатгал	12,609,500.00	10,388,700.00	-2,220,800.00	82.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,861,500.00	90,519,067.00	-342,433.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	3,142,300.00	2,951,257.00	-191,043.00	93.9
210302	Түлш, халаалт	86,619,200.00	86,467,810.00	-151,390.00	99.8
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,100,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	19,401,000.00	18,357,630.00	-1,043,370.00	94.6
210401	Бичиг хэрэг	1,369,100.00	1,369,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,100,000.00	5,100,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,760,600.00	1,703,000.00	-1,057,600.00	61.7
210404	Ном, хэвлэл	4,111,100.00	4,111,000.00	-100.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	535,000.00	575,000.00	40,000.00	107.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,525,200.00	5,499,530.00	-25,670.00	99.5
2105	Нормативт зардал	76,081,500.00	45,652,065.00	-30,429,435.00	60.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,004,500.00	2,004,500.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	61,572,500.00	31,143,865.00	-30,428,635.00	50.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,504,500.00	12,503,700.00	-800.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,441,400.00	71,419,700.00	-21,700.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,350,000.00	7,350,000.00	0.00	100.0
210602	Тавилга	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	56,091,400.00	56,069,700.00	-21,700.00	100.0

**Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2107	Томилолт, зочны зардал	1,096,700.00	1,094,000.00	-2,700.00	99.8
210702	Дотоод албан томилолт	1,096,700.00	1,094,000.00	-2,700.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,806,700.00	1,806,700.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,356,700.00	1,356,700.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32904200.00	32878770.00	-25,430.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,904,200.00	17,878,770.00	-25,430.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22960800.00	16578500.00	-6,382,300.00	72.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,960,800.00	16,578,500.00	-6,382,300.00	72.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,248,000.00	14,865,700.00	-6,382,300.00	70.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,712,800.00	1,712,800.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,005,339,500.00	951,843,550.00	-53,495,950.00	94.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	911,478,000.00	858,315,483.00	-53,162,517.00	94.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	911,478,000.00	858,315,483.00	-53,162,517.00	94.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,861,500.00	93,519,067.00	-342,433.00	99.6
132001	Орон нутгийн төсвөөс	93,861,500.00	93,519,067.00	-342,433.00	99.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	9,000.00	9,000.00	#DIV/0!
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	9,000.00	9,000.00	#DIV/0!
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	48.00	48.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	500.00	483.00	-17.00	96.6
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	500.00	483.00	-17.00	96.6
630001	Төрийн өмчит ЕБС	500.00	483.00	-17.00	96.6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	48.00	48.00	0.00	100.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	30.00	30.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18.00	18.00	0.00	100.0


 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ЗСБАНЦАГЧ
 ОЛГОЛГО АЖИЛЛАГА

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

				/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	46,879,118.00	46,879,118.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	46,879,118.00	46,879,118.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2,131,100.00	2,131,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00		-
210404	Ном, хэвлэл	0.00	2,131,100.00	2,131,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	44,748,018.00	44,748,018.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	44,748,018.00	44,748,018.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	44,748,018.00	44,748,018.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	46,879,118.00	46,879,118.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	44,748,018.00	44,748,018.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	2,131,100.00	2,131,100.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Баянговь сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Ц.Буянтогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн программд гүйлгээний утгыг бүрэн оруулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, тухай бүрд мэдээллийг оруулж байх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянговь сумын ЕБС 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.24-ний өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага “Амьдрах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвартай, эрүүл, өөртөө итгэлтэй, хүнлэг, зөв монгол хүүхэд төлөвшүүлэх” эрхэм зорилго тавьж ажилласан байна.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянговь сумын ЕБС нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.

Баянговь сумын ЕБС нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Тайлант онд тус байгууллагад хяналт байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Баянговь сумын ЕБС-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна..

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг үр дүнгийн тайлангийн зардлын 2.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1 хувиар буюу 10142.7 мянган төгрөгөөр тооцов.

Аудитыг гүйцэтгэх явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянговь сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1433301.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 67497.6 мянган төгрөгөөр буюу 4.94 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(мян.төг)
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,817.8	135,159.8	56,342.0
Авлага	-	11,116.4	11,116.4
Бараа материал	78,817.8	124,043.4	45,225.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,286,986.2	1,298,141.8	11,155.6
Үндсэн хөрөнгө	1,565,131.2	1,551,409.1	(13,722.1)
Хуримтлагдсан элэгдэл	(278,145.0)	(253,267.3)	24,877.8
Нийт хөрөнгө	1,365,804.0	1,433,301.6	67,497.6
Өр төлбөр	794.4	-	(794.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,365,009.6	1,433,301.6	68,292.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,365,804.0	1,433,301.6	67,497.6


Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Өмнөх онд авлагагүй ажилласан бөгөөд оны эцэст төсөвт зохицуулалт хийж, "Санкомаркетинг" ХХК-аас ухаалаг самбарын үнэнд 9950.0 мянган төгрөгийг шилжүүлж, авлагаар бүртгэж, хувь хүний орлогын албан татварын илүү шилжүүлсэн 275.9 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 890.4 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 124043.4 мянган төгрөг болж өмнөх оноос 45225.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд 3423.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр авсан, төсвийн хөрөнгөөр 30965.6 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, 2436.1 мянган төгрөгийг үйл ажиллагаанд олгосон, ариун цэврийн байгууламжийн зардалд 25000.0 мянган төгрөгийг шилжүүлж, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 1565131.2 мянган төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 53136.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, бусад байгууллагаас 26906.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч, холбогдох байгууллагын шийдвэрээр 93765.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 67497.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 1433301.6 мянган төгрөг болсон байна.

Баянговь сумын ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлэг өмнөх оноос 96149.1 мянган төгрөгөөр буюу 18.9 хувиар өсөж, орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлын санхүүжилт 10328.8 мянган төгрөг буюу 9.63 хувиар буурсан бөгөөд, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг төлөвлөдөггүй байна.

Нийт зардал өмнөх онд 866054.0 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 85789.5 мянган төгрөгөөр буюу 9.9 хувиар өсөж, 951843.6 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн 34475.0 мянган төгрөгөөр өөрчлөгдсөн нь тайлант хугацаанд хичээлийн байрыг акталснаас 15837.0 мянга, мод боловсруулах кабинет 18638.0 мянган төгрөгөөр өмнөх оны үр дүнд бичилт хийсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 911478.0 мянга, орон нутгийн төсвөөс 93861.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авч, туслах үйл ажиллагааны орлогоор албан баланк буруу бичиж буцаан төлүүлсэн албан баланкны орлогоор 9.0 мянган төгрөгийг оруулж, урсгал үйл ажиллагаанд 951843.6 мянган төгрөгийг зарцуулан, оны эцэст 53504.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.


Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 46879.1 мянган төгрөгийн орлого орсноос аймгийн БСУГ-аас хуулийн дагуу олгох тэтгэмжийн санхүүжилтийн 44748.0 мянган төгрөгийг албан хаагчдад тэтгэмжийг бүрэн олгож, 2131.1 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийн үнийг БСШУЯ-ны СБТТ-эргэлтийн санд төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийн 78.1 хувь буюу 118 мэдээллийг хугацаанд нь оруулж, 21.9 хувь буюу 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

Хүснэгт 2. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	11	11	10	1
2	Хагас жил	4	4	4	
3	Улирал бүр	1	4	2	2
4	Сар бүр	3	36	23	13
5	Тухай бүр	8	96	79	17
	Нийт	27	151	118	33

Эх сурвалж: Баянговь сумын ЕБС-ийн шилэн данс

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитыг “Хонгор үр сад” ХХК-ийн аудитор Б.Бямбаа хийж гүйцэтгэн зөвлөмж өгөөгүй бөгөөд аудитаар хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийснээс 1405.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 141.1 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байгаа тул 2021.03.10-ны дотор өмнөх төлбөрийг барагдуулахаар шийдвэрлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 47299.4 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт тайлагналын алдаатай холбоотой 33287.4 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн цэстээр 596899.8 мянган төгрөгийн цалин олгосон байхад үр дүнгийн тайланд зардлыг 13547.7 мянган төгрөгөөр илүү буюу 610447.5 мянган төгрөгөөр тусгасан.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд цалингийн зардлыг нэмэгдүүлж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлыг бууруулж залруулав.

2. Аймгийн БСУГ-аас дамжуулан олгосон тэтгэмжийн 19739.7 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосноор санхүүгийн тайланд тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн санхүүжилтийг бууруулж, нэмэлт санхүүжилтийн орлогыг нэмэгдүүлж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 15178.3 мянган төгрөгийн 6 залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 8572.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2486.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4119.4 мянган төгрөгийн 2 алдаанд зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

1. Тайлант оны 12 дугаар сард нормын хувцас худалдан авах зардлаас нэг бүр нь 120.0 мянган төгрөгийн 11 эмэгтэй ажлын хувцсыг 1320.0 мянган төгрөгөөр авч бараа материалд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төсвийн хөрөнгөөс хувь хүний орлогын албан татварын илүү шилжүүлсэн 275.9 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 890.4 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн

Шийдвэрлэсэн нь: Байгууллагаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Аж ахуйн материалд тайлант онд худалдан авсан 460.0 мянган төгрөгийн угаалгын машин, 420.0 мянган төгрөгийн скайнер, 180 мянган төгрөгийн сандал, 1950.0 мянган төгрөгийн 3 ширхэг ус буцалгагч, өмнөх онуудад бэлтгэсэн 1600.0 мянган төгрөгийн булангийн буйдан, 330.0 мянган төгрөгийн угаалгын машин зэрэг үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг залруулж бүртгэх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 4119.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Нягтлан бодогч санхүүгийн тайлангийн аудит хийх хугацаанд аудитад шаардлагатай баримт материал, тодруулгыг заасан цаг хугацаанд хурдан шуурхай гаргаж өгөх, ерөнхий дэвтрийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, гүйлгээний утгыг бүрэн оруулах талаар анхаарч ажиллах шаардлагатай.

Тус байгууллага төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авахдаа зах зээлийн үнийн судалгаа хийдэггүй, биеийн тамирын суултын төхөөрөмж зэрэг хөрөнгө нэн шаардлагатай байсан эсэхийг дараагийн аудитаар тодруулж үзэн, ашиглалтын байдалд дүгнэлт өгөх, хөрөнгийг бөөн дүнд нь орлогод авах зэргийг шалах нь зүйтэй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

- 1.1. **Илрүүлэлт:** Нягтлан бодогч санхүүгийн программд гүйлгээний утгыг бүрэн оруулдаггүй, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, нярвын тайланг хянаж албажуулаагүй, нярав сар бүр материалын тайлан гаргаагүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтлөөгүй байх, анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээг бүртгээгүй байх.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн тайлан бэлтгэж байгаа санхүүгийн программд гүйлгээний утгыг бүрэн оруулж, анхан шатны баримтын иж бүрдлийг хянаж хууль, журмыг мөрдөж санхүүгийн тайланг бэлтгэж байх.
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

2. ТӨСВИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

- 2.1. **Илрүүлэлт:** Шилэн дансны тухай хуулийг мөрдөөгүйгээс тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийн 21.9 хувь буюу 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.
- 2.2. **Эрсдэл:** Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байх.
- 2.3. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлж, хугацаанд нь мэдээллийг цахим хуудаст мэдээлж байх
- 2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.25



5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Баянговь сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/15/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Тайлант оны 12 дугаар сард нормын хувцас худалдан авах зардлаас нэг бүр нь 120.0 мянган төгрөгийн 11 эмэгтэй ажлын хувцсыг 1320.0 мянган төгрөгөөр авч бараа материалд бүртгэсэн.	1320.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
2	Төсвийн хөрөнгөөс хувь хүний орлогын албан татварын илүү шилжүүлсэн 275.9 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 890.4 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн.	1166.3	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
3	Цалингийн цэстээр 596899.8 мянган төгрөгийн цалин олгосон байхад үр дүнгийн тайланд зардлыг 13547.7 мянган төгрөгөөр илүү буюу 610447.5 мянган төгрөгөөр тусгасан.	13547.7	Санхүүгийн тайланд залруулах	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
4	Аймгийн БСУГ-аас дамжуулан олгосон тэтгэмжийн 19739.7 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосноор санхүүгийн тайланд тайлагнасан.	19739.7	Санхүүгийн тайланд залруулах	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
5	2019 онд худалдан авсан 1350,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэх жилийг программын өгөгдөлд оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй, 2020.02.17-ны өдөр "Грийн Химистри" ХХК-аас авсан 1019.4 мянган төгрөгийн 136 ширхэг, Медимпекс интернейшнл ХХК-аас авсан 9 нэр төрлийн 1263.2 мянган төгрөгийн 29 ширхэг хичээлийн хэрэглэгдэхүүнийг бөөн дүнгээр бүртгэж авсан.	3632.6	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
6	Аж ахуйн материалд тайлант онд худалдан авсан 4940,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн.	4940.0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал

**Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

А	1	2	3	4	5
7	Нягтлан бодогч санхүүгийн программд гүйлгээний утгыг бүрэн оруулдаггүй, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, нярвын тайланг хянаж албажуулаагүй, нярав сар бүр материалын тайлан гаргаагүй.	1019.4	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
8	Шилэн дансны тухай хуулийг мөрдөөгүйгээс тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийн 21.9 хувь буюу 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.	3100.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
ДҮН		48465.7			

---oOo---